

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ОХУ	Оросын холбооны улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл	20
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.9. Аудитын илрүүлэлт	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	21
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Ч.ЧИМЭДРАГЧАА ТАНАА

2021.02.25 № 07/573
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга илэрхийлсэн толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	622,848,293.08	568,025,354.29
33	АВЛАГА	39,426,096.70	59,369,731.37
335	Бусад авлага	39,426,096.70	59,369,731.37
3351	Байгууллагаас авах авлага	39,096,096.70	59,039,731.37
3352	Хувь хүмүүсээс авах авлага	330,000.00	330,000.00
34	УРЬДЧИЛГАА	213,807,083.00	145,656,073.00
34600	Урьдчилж гарсан зардал	194,795,183.00	126,644,173.00
3471	Урьдчилгаа тооцоо	19,011,900.00	19,011,900.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	19,011,900.00	19,011,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	369,615,113.38	362,999,549.92
351	Түүхий эд материал	169,433,198.96	215,950,343.73
35110	Тусгай зориулалттай материал	140,894,428.86	107,644,520.46
35130	Эм боох материал	28,538,770.10	57,353,798.28
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	9,764,077.25	3,863,818.23
35300	Бэлэн бүтээгдэхүүн	37,758,785.54	47,088,206.76
354	Хангамжийн материал	149,999,612.75	144,289,872.94
35410	Бичиг хэргийн материал	96,588,491.00	71,925,291.00
35420	Аж ахуйн материал	1,137,638.02	663,458.02
35440	Түлш, шатах тослох материал	339,167.71	537,471.35
35450	Барилгын засварын материал	24,312,254.35	24,912,254.35
35460	Хүнсний материал	8,738,318.09	16,287,763.00
35470	Бусад хангамжийн материал	18,883,743.58	29,963,635.22
35600	Мал амьтад	2,659,438.88	2,759,333.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,281,242,868.36	2,058,140,715.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,281,242,868.36	2,058,140,715.92
392	Биет хөрөнгө	1,689,139,408.26	1,466,677,255.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,444,208,366.98	1,444,208,366.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	(125,597,358.91)	(234,933,203.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,287,400.00	57,287,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(53,037,400.05)	(57,162,399.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,336,693,071.91	1,339,744,175.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,022,371,473.28)	(1,121,499,308.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	240,243,564.79	237,047,203.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(188,286,763.18)	(198,014,978.03)
393	Биет бус хөрөнгө	592,103,460.10	591,463,460.14
39301	Програм хангамж	6,241,500.00	5,224,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,741,499.90)	(3,363,999.86)
39303	Бусад биет бус хөрөнгө	591,840,960.00	591,840,960.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,237,500.00)	(2,237,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,904,091,161.44	2,626,166,070.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,808,531.82	180,004.16
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,808,531.82	180,004.16
413	Өглөг	2,808,531.82	180,004.16
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,808,291.82	0.00
4136	Бусад өглөг	240.00	180,004.16
41361	Байгууллагад төлөх өглөг	240.00	150,004.16

41362	Хувь хүмүүст төлөх өглөг		30,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,901,282,629.62	2,625,986,066.05
51	Засгийн газрын хувь оролцоо	2,901,282,629.62	2,625,986,066.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,875,411,193.51	2,875,411,193.51
	Өмч: - төрийн	2,875,411,193.51	2,875,411,193.51
512	Хуримтлагдсан үр дүн	(522,480,099.01)	(794,208,310.08)
51210	Өмнөх үеийн үр дүн	(522,480,099.01)	(518,911,746.51)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(275,296,563.57)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	548,351,535.12	544,783,182.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,904,091,161.44	2,626,166,070.21

2. 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,831,156,717.72	3,141,236,089.47
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	526,528,717.72	165,492,821.47
120	Нийтлэг татварын бус орлого	526,528,717.72	165,492,821.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	526,528,717.72	165,492,821.47
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,624,045.43	136,485,324.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,229,515.14	14,279,624.47
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	51,675,157.15	14,727,873.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,304,628,000.00	2,975,743,268.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	847,074,900.00	488,869,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	847,074,900.00	488,869,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,345,000.00	513,011,268.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	103,345,000.00	513,011,268.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,354,208,100.00	1,973,862,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,354,208,100.00	1,973,862,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,101,030,041.77	3,416,477,526.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,101,030,041.77	3,416,477,526.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,078,078,041.77	3,320,530,513.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,392,221,218.00	883,586,205.00
210101	Үндсэн цалин	970,734,658.00	1,284,636,709.00
210102	Нэмэгдэл	218,220,400.00	376,122,982.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	128,244,300.00	132,073,995.00
210104	Урамшуулал	75,021,860.00	90,752,519.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,171,057.82	240,981,322.67
210201	Тэтгэврийн даатгал	125,677,391.82	178,242,440.67
210202	Тэтгэмжийн даатгал	14,097,879.00	16,663,194.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,103,770.00	12,863,515.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,560,589.00	3,006,869.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,702,972.00	30,205,304.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,731,768.93	132,081,786.33
210301	Гэрэл, цахилгаан	48,535,296.00	51,581,592.19
210302	Түлш, халаалт	50,143,604.93	47,093,078.14
210303	Цэвэр, бохир ус	36,052,868.00	33,407,116.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,389,359.58	95,023,089.21
210401	Бичиг хэрэг	4,212,150.00	6,904,005.00
210402	Тээвэр, шатахуун	4,847,995.00	5,612,905.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,953,810.08	8,694,688.85
210404	Ном, хэвлэл	112,905.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,512,740.00	14,284,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,839,990.00	31,150,820.00
210408	Бараа материал акталсны зардал	18,909,769.50	28,376,270.00
2105	Нормативт зардал	390,712,416.77	370,166,552.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	168,246,977.33	184,819,043.94
210502	Хоол, хүнс	213,228,889.44	177,590,758.09

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,236,550.00	7,756,75.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,555,008.00	42,514,550.00
210604	Урсгал засвар	20,555,008.00	42,514,550.00
2107	Томилолт, зочны зардал	2,475,000.00	6,798,000.00
210702	Дотоод албан томилолт	2,475,000.00	6,798,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	431,505,934.37	169,190,816.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	418,443,564.37	157,181,246.89
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	155,400.00	114,480.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,600.00	163,800.00
210807	Газрын төлбөр	3,669,970.00	3,667,240.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	16,000.00	00.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,519,400.00	5,564,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	453,344,734.30	380,188,191.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176,597,812.94	106,508,434.70
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	276,746,921.36	273,679,756.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,609,461.98	95,947,012.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,952,000.00	88,978,260.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,202,000.00	86,458,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,750,000.00	2,519,760.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,900,740.49	6,968,752.82
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		6,139,983.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,900,411.49	828,769.00
213304	Хөрөнгийн	329.00	00.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,756,721.49	00.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,756,721.49	00.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(269,873,324.05)	(275,241,436.62)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.0	(55,126.95)
	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны /гарз/	00.0	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.0	(55,126.95)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.0	(55,126.95)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(269,873,324.05)	(275,296,563.57)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,768,293,228.49	3,098,248,079.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	463,665,228.49	139,485,324.00
120	Нийтлэг татварын бус орлого	463,665,228.49	39,485,324.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	463,665,228.49	139,485,324.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	459,233,868.49	136,485,324.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,431,360.00	3,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,304,628,000.00	2,958,762,755.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	847,074,900.00	488,869,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	847,074,900.00	488,869,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,345,000.00	496,030,755.00
131105	өсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	103,345,000.00	496,030,755.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,354,208,100.00	1,973,862,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,354,208,100.00	1,973,862,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,687,530,438.49	3,061,562,045.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,687,530,438.49	3,061,562,045.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,654,920,976.51	2,965,645,031.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,391,404,911.00	1,884,096,770.00
210101	Үндсэн цалин	969,918,351.00	1,295,382,751.00
210102	Нэмэгдэл	218,220,400.00	376,122,982.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	128,244,300.00	121,838,518.00
210104	Урамшуулал	75,021,860.00	90,752,519.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,178,909.00	245,111,277.00
210201	Тэтгэврийн даатгал	122,729,320.00	182,372,395.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,913,482.00	16,663,194.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,307,747.00	12,863,515.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,557,388.00	3,006,869.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,670,972.00	30,205,304.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,731,768.93	132,081,786.33
210301	Гэрэл, цахилгаан	48,535,296.00	51,581,592.19
210302	Түлш, халаалт	50,143,604.93	47,093,078.14
210303	Цэвэр, бохир ус	36,052,868.00	33,407,116.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,202,760.08	89,225,543.85
210401	Бичиг хэрэг	5,790,050.00	7,204,775.00
210402	Тээвэр, шатахуун	4,369,620.00	5,641,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,953,810.08	8,694,688.85
210404	Ном, хэвлэл	00,0	600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,048,080.00	16,232,720.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,041,200.00	50,851,410.00
2105	Нормативт зардал	363,518,186.50	478,342,963.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,660,247.20	283,923,583.00
210502	Хоол, хүнс	174,547,039.30	184,687,680.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	27,310,900.00	9,731,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,164,008.00	42,645,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,324,000.00	209,990.00
210604	Урсгал засвар	17,840,008.00	42,436,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,577,400.00	6,798,000.00
210702	Дотоод албан томилолт	3,577,400.00	6,798,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	491,853,492.00	72,022,851.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	479,696,522.00	58,481,031.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	155,400.00	114,480.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,600.00	163,800.00
210807	Газрын төлбөр	3,669,970.00	3,667,240.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	16,000.00	00.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,614,000.00	7,096,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,289,541.00	15,319,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,289,541.00	15,319,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,609,461.98	95,917,013.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,952,000.00	88,948,261.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,202,000.00	86,458,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,750,000.00	2,489,761.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,657,461.98	6,968,752.82
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.0	6,139,983.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,657,461.98	828.770.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	80,762,790.00	36,686,034.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	80,762,790.00	36,686,034.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80,762,790.00	36,686,034.00
2200	Дотоод эх үүсвэрээр	80,762,790.00	36,686,034.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,762,790.00	36,686,034.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(80,762,790.00)	(36,686,034.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,411,193.51	548,351,535.12	(241,949,312.98)	3,181,813,415.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,000,000.00)	(1,000,000.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,875,411,193.51	548,351,535.12	(242,949,312.98)	3,180,813,415.65
Тайлант үеийн үр дүн		-	(279,530,786.03)	(279,530,786.03)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,411,193.51	548,351,535.12	(522,480,099.01)	2,901,282,629.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,568,352.50	3,568,352.50
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,875,411,193.51	548,351,535.12	(518,911,746.51)	2,904,850,982.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(3,568,352.50)		(3,568,352.50)
Тайлант үеийн үр дүн			(275,296,563.57)	(275,296,563.57)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,411,193.51	544,783,182.62	(794,208,310.08)	2,625,986,066.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	2,625,732,000.00	2,596,077,340.18	29,654,659.82	98.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,537,006,000.00	2,507,466,579.18	29,539,420.82	98.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,610,477,600.00	1,610,214,438.00	263,162.00	100.0
Үндсэн цалин	950,071,700.00	1,026,062,525.00	(75,990,825.00)	108.0
Нэмэгдэл	413,313,400.00	376,122,982.00	37,190,418.00	91.0
Унаа хоолны хөнгөлөлт	128,244,300.00	121,838,518.00	6,405,782.00	95.0
Урамшуулал	118,848,200.00	86,190,413.00	32,657,787.00	72.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,536,900.00	208,517,896.00	19,004.00	100.0
Тэтгэврийн даатгал	147,442,300.00	145,779,014.00	1,663,286.00	98.9
Тэтгэмжийн даатгал	15,273,600.00	16,663,194.00	(1,389,594.00)	109.1
ҮОМШӨ-ний даатгал	12,218,900.00	12,863,515.00	(644,615.00)	105.3
Ажилгүйдлийн даатгал	3,054,700.00	3,006,869.00	47,831.00	98.4
Эрүүл мэндийн даатгал	30,547,400.00	30,205,304.00	342,096.00	98.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,106,900.00	126,375,108.33	1,025,113.67	94.9
Гэрэл, цахилгаан	41,581,700.00	48,695,526.19	(9,999,892.19)	117.1
Түлш, халаалт	54,956,300.00	44,272,466.14	7,863,221.86	80.6
Цэвэр, бохир ус	36,568,900.00	33,407,116.00	3,161,784.00	91.4
Хангамж, бараа материалын зардал	75,997,600.00	67,338,133.85	8,659,466.15	88.6
Бичиг хэрэг	6,411,500.00	4,529,105.00	1,882,395.00	70.6
Тээвэр, шатахуун	3,891,900.00	3,130,800.00	761,100.00	80.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,752,900.00	8,694,688.85	58,211.15	99.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,500,000.00	16,232,720.00	267,280.00	98.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,441,300.00	34,750,820.00	5,690,480.00	85.9
Нормативт зардал	367,941,800.00	367,544,333.00	397,467.00	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	197,027,900.00	193,554,853.00	3,473,047.00	98.2
Хоол, хүнс	159,659,000.00	166,724,980.00	(7,065,980.00)	104.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,254,900.00	7,264,500.00	3,990,400.00	64.5
Эд хогшил, урсгал засварын зардал	70,844,100.00	57,609,730.00	13,234,370.00	81.3
Багаж, техник, хэрэгсэл	40,000,000.00	27,232,630.00	12,767,370.00	68.1
Урсгал засвар	30,844,100.00	30,377,100.00	467,000.00	98.5
Томилолт, зочны зардал	2,542,800.00	2,454,000.00	88,800.00	96.5
Дотоод албан томилолт	2,542,800.00	2,454,000.00	88,800.00	96.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,236,100.00	52,093,090.00	143,010.00	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,574,200.00	38,551,270.00	22,930.00	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00		100.0
Даатгалын үйлчилгээ	114,500.00	114,480.00	20.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	163,800.00	163,800.00	-	100.0
Газрын төлбөр	3,670,600.00	3,667,240.00	3,360.00	99.9
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00		99,000.00	0.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,114,000.00	7,096,300.00	17,700.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	15,322,200.00	15,319,850.00	2,350.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	15,322,200.00	15,319,850.00	2,350.00	100.0

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,726,000.00	88,610,761.00	115,239.00	99.9
Бусад урсгал шилжүүлэг	88,726,000.00	88,610,761.00	115,239.00	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	86,458,500.00	86,458,500.00		100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,267,500.00	2,152,261.00	115,239.00	94.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,625,732,000.00	2,596,077,340.18	29,654,659.82	98.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	488,869,700.00	482,729,716.18	6,139,983.82	0.0
Улсын төсвөөс санхүүжих	488,869,700.00	482,729,716.18	6,139,983.82	98.7
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,973,862,300.00	1,973,862,300.00		98.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,973,862,300.00	1,973,862,300.00	-	100.0
Төсөв байгууллагын үйл ажиллагааны орлого	163,000,000.00	139,485,324.00	23,514,676.00	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,140,000.00	136,485,324.00	23,654,676.00	85.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,860,000.00	3,000,000.00	(140,000.00)	85.2
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,625,732,000.00	2,596,077,340.18	29,654,659.82	104.9
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	488,869,700.00	482,729,716.18	6,139,983.82	98.9
АЖИЛЛАГСАДЫН ТОО	113	113		
Удирдах ажилтан	1	1	-	
Гүйцэтгэх ажилтан	112	112		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		496,030,755.00
УРСГАЛ ЗАРДАЛ		496,030,755.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		494,864,486.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		273,882,332.00
Үндсэн цалин		269,320,226.00
Нэмэгдэл		4,562,106.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		36,593,381.00
Тэтгэврийн даатгал		36,593,381.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		5,706,678.00
Гэрэл, цахилгаан		2,886,066.00
Цэвэр, бохир ус		2,820,612.00
Хангамж, бараа материалын зардал		21,887,410.00
Бичиг хэрэг		2,675,670.00
Тээвэр, шатахуун		2,511,150.00
Ном, хэвлэл		600,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		16,100,590.00
Нормативт зардал		110,798,630.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		90,368,730.00
Хоол, хүнс		17,962,700.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,467,200.00
Эд хогшил, урсгал засварын зардал		21,722,294.00
Багаж, техник, хэрэгсэл		9,663,394.00
Урсгал засвар		12,058,900.00
Томилолт, зочны зардал		4,344,000.00
Дотоод албан томилолт		4,344,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,929,761.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		19,929,761.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,166,269.00
Бусад урсгал шилжүүлэг		1,166,269.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		337,500.00
өвлөрүүлэх шилжүүлэг /нэмэнлт/		828,769.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		496,030,755.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		496,030,755.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		496,030,755.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ч.Чимэдрагчаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 04-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Гроут финанс Аудит” ХХК-ийн захирал Б.Бямба, аудитор Б.Даваасүрэн, туслах аудитор Т.Гантуул нар хариуцаж хэрэгжүүлэв.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гроут финанс Аудит-д 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 01/10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай зохистой хослуулан хөгжүүлэх үүднээс уламжлалт анагаах ухааны онол аргагүй, оношлогоо, эмчилгээний арга барил, эмт бодисын шинжлэх ухааны үндэслэлийг тогтоох
- Уламжлалт жоронд ордог ургамал, амьтан, эрдсийн гаралтай түүхий эдийн тархац, байршил, нөөц ховордсон ба гадаадаас авдаг эмийн ургамлын тарималжуулалт, фитохими, эм судлал, эмнэл зүй, стандартчилал, технологи, шинэ эм бүтээх, мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг явуулж шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эмнэлгийн практикт нэвтрүүлэх, үр өгөөжийг нь дээшлүүлэх
- Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэх, эмчилгээний нэр төрлийг олшруулах,
- Уламжлалт эм үйлдвэрлэлийг технологийн өндөр түвшинд үйлдвэрлэх, эмийн сав баглаа боодлыг сайжруулах

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн нь Эрдэм шинжилгээний төв, Клиник эмнэлэг, Уламжлалт эмийн үйлдвэр гэсэн үндсэн нэгжтэй санхүү, маркетингийн алба, хангамж үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, эмийн ургамал тарималжуулах плантаци, хүдрийн эрдэм шинжилгээний станци, "Ургамал" сувилал, амбулаторийн салбар тасаг, жижиг амьтны вивари зэрэг туслах нэгжүүдтэйгээр үйл ажиллагаа явуулдаг

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн ч байгууллагын үйл ажиллагаатай онцлогтой нийцээгүй байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй, тус хүрээлэнгийн өөрийн дотоод хяналтын ажилтан нь 2020 онд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сар бүр, худалдан авах үйл ажиллагаа нь хуулийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийсэн байна.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,640,249.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,402.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг хэвээр авч 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,416,532.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 34,165.3 мянган төгрөгөөр тооцон авлаа.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 279,645.4 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлагын данс өссөн, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн данс буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны нэр 2	Тайлант оны эхний үлдэгдэл 3	Тайлант оны эцсийн үлдэгдэл 4	Зөрүү	
			Дүн 5	Хувь 6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	622,848.3	568,025.4	(56,543.0)	(9.1)
МӨНГӨН ХӨРӨНГӨ				
АВЛАГА	39,426.1	59,369.7	19,943.6	46.2
УРЬДЧИЛГАА	213,807.1	145,656.1	(68,151.0)	(31.9)
БАРАА МАТЕРИАЛ	369,615.1	362,999.5	(6,615.6)	(1.8)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,281,242.9	2,058,140.7	(223,102.1)	(9.8)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,281,242.9	2,058,140.7	(223,102.1)	(9.8)
Нийт хөрөнгө дүн	2,904,091.2	2,626,166.1	(277,925.1)	(9.6)
4 НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,808.5	180.0	(2,628.5)	(93.6)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,808.5	180.0	(2,628.5)	(93.6)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,901,282.6	2,626,166.1	(275,116.5)	(9.6)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,904,091.2	2,626,166.1	(277,925.1)	(9.6)

Авлага дансны үлдэгдэл 59,369.7 мянган төгрөг болж 19,943.6 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор харилцагч байгууллагын төлбөрийн чадвар буурснаас шалтгаалсан. 2012 онд үүссэн гол харилцагч болох ОХУ-ын Новая Ази компаниас авах 38,638.1 мянган төгрөгийн авлагыг одоо ОХУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгүүлэх албанд албадан гүйцэтгүүлэх ажиллагаа явагдаж байгаа.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 145,656.1 мянган төгрөг болж 68,151.0 мянган төгрөгөөр буурсан нь эрдэм шинжилгээний төслийн 2 ажил хүлээлгэн өгсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 362,999.5 мянган төгрөг болж 6,615.6 мянган төгрөгөөр буурсан нь эрдэм шинжилгээний төслийн санхүүжилт хийгдээгүйгээс тусгай зориулалтын материалын үлдэгдлээс 21,881.1 мянган төгрөгийн материал зарцуулсан мөн ашиглалтын шаардлага хангахгүй 42,812.7 мянган төгрөгийн материалыг акталж устгаснаас шалтгаалсан. Бараа материалын данс нь төсвийн хөрөнгөөр 492,167.0 мянган төгрөг, өөрийн орлогоор 128,211.4 мянган төгрөг, хандив тусламжаар 836.3 мянган төгрөгөөр өсөж, 712,527.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулан, 93,124.4 мянган төгрөгийн эм борлуулж 363,027.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,058,140.7 мянган төгрөг болж 223,102.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд элэгдлийн зардал 273,673.7 мянган төгрөг, 51,740.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 592 дугаар тогтоолын дагуу акталснаас шалтгаалсан. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн хөрөнгөөр 36,686.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БШУЯ-наас хандив тусламжаар 13,891.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө нэмэгдээгүй, 1,017.5 мянган төгрөгийн програмыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 592 дугаар тогтоолын дагуу акталж, 3,364.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийн хорогдлоор буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 180.0 мянган төгрөг болж 2,628.5 мянган төгрөгөөр буурсан нь ХАОАТ, НДШ-ийн оны эхний үлдэгдэлийг төлсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,625,986.1 мянган төгрөг болж 275,296.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилд үр дүн алдагдалтай байснаас шалтгаалжээ.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 310,079.4 мянган төгрөгөөр буюу 11.0 хувиар өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилт 619,654.2 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлого 48,125.8 мянган төгрөгөөр тус тус өсөж, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 361,035.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 315,502.6 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 313,902.0, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал 3,771.7 мянган төгрөгөөр тус бүр өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,842,763.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,842,763.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,217,031.00 мянган төгрөгөөр бууруулж 2,625,732.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тус байгууллага нь 24 эрдэм шинжилгээний ажилтан, эмнэлгийн албан хаагчдын тоог нэмэх санал оруулсан боловч нэмээгүйгээс цалин, нийгмийн даатгалын зардал 395,360.55 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 286,892.74 мянган төгрөг, бичиг хэрэг хангамжийн зардал 21,858.3 төгрөг, хог хаягдал, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал 48,631.93 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,628.3 мянган төгрөгөөр, хангамж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 384,278.1 мянган төгрөгөөр, хоол, эм эмнэлгийн хэрэгсэл зардал 92,281.24 мянган төгрөг бараа үйлчилгээний бусад зардлыг 61,686.64 мянган төгрөгөөр тус бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,625,732.0 мянган төгрөгийн төсөв (САГ-2021/82/СТА-ТШЗ)

баталснаас 488,869.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 1,973,862.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих, 163,000.0 үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 488,869.7 мянган төгрөгийн санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,973,862.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 139,485.3, нийт 2,602,217.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,596,077.3 мянган төгрөгийг зарцуулж 6,140.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,596,077.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,731.79 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 8,659.47 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 13,234.37 мянган төгрөгөөр, тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 163,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 139,485.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 85.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	160,140.0	136,485.3	23,654.7	85.2
Туслах үйл ажиллагааны орлого	2,860.0	3,000.0	(140.0)	104
Нийт дүн	163,000.0	139,485.3	23,654.7	85.6

Энэ онд Ковид-19 цар тахлын улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн тоо сүүлийн сард буурсантай холбоотой орлого бага зэрэг буурсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд эмийн борлуулалтын орлого 361,025.6 мянга, сургалтын төлбөрийн орлого 74,655.6 мянга, гачуурт сувиллын орлого 48,692.0 мянга, тусламж хандивын орлого 10,000.0 мянган төгрөг тус бүр нийт 496,030.8 мянган төгрөгийг орлогыг бүрдүүлж, Урсгал үйл ажиллагаанд 495,201.96 мянган төгрөгийг зарцуулж 828.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг байршуулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд байршуулбал зохих 352 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 349 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байршуулж шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 99.1 хувьтай байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 59,254.9 мянган 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	59,254.9	5	59,254.9	-	-	-
Нийт дүн	5	59,254.9	5	59,254.9	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,291.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1720.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 10,571.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагнахын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Цалингийн зардлын дансанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд илүү тооцсон нийгмийн даатгалын шийтгэлийн зардал 1,570.3 мянган төгрөг, ажилчдаас илүү суутгасан нийгмийн даатгалын шимтгэл 150.0 мянган төгрөг, ХАОАТ-ын илүү төлөлт 1,720.3 мянган төгрөг тус бүрийг холбогдох дансанд залруулга хийн санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаж залруулав.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 10,571.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн нь 2011 оны 02 дугаар сарын 21-ний өдөр ОХУ-ын Новая Ази компанитай худалдах, худалдан авах гэрээ байгуулан. Гэрээний үлдэгдэл төлбөр болох 18,860.0 ам долларын авлага тухайн үеийн монгол банкны ханшаар 38,638.1 мянган төгрөг санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын ба Үндэсний арбитр нь Новая Ази компаниас гэрээний үлдэгдэл төлбөр, арбитрын зардлыг гаргуулахаар 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 173 дугаар шийдвэр гаргасан. ОХУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгүүлэх албанд албадан гүйцэтгүүлэх нэхэмжлэл гаргасан нь хэрхэн шийдвэрлэснийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг 10,485.5 мянган төгрөгөөр илүү тооцон зардалд тусгасан. Энэ нь тайланд онд ашиглалтын жил дуусаж байгаа хөрөнгүүд дээр элэгдлийг илүү тооцсон байна.

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 4.35 “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4. “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн хөрөнгийн дансны үнэ зөрүүтэй тооцогдож, элэгдлийн зардал илүү дүнгээр тусгагдаж тайлант оны үр дүнд нөлөөлөх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4. “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсний дагуу санхүүгийн программын тооцооллыг нягталж байх, мөн санхүүгийн программын үндсэн хөрөнгийн бүртгэлд сайжруулалт хийх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн 232 нэр төрлийн 2,136 ширхэг 417,909.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Санхүүгийн тайланд нийт 232 нэр төрлийн 2,236 ширхэг үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ба тэдгээрийн ашиглалтын байдал тооллогын бүртгэлээр чанар байдлыг тодорхойлоогүй байна.

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 3-2.-той нийцэхгүй байна.

2.2 Эрсдэл:

Хөрөнгө санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ илэрхийлэгдэхгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 3-2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээ анхны үнийг нөхсөн түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг ТӨБЗГ-тай зөвшилцөж шийдвэрлэнэ гэснийг мөрдөж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дахин үнэлгээ хийлгэх саналаа ТӨБЗГазарт хүргүүлж ажиллана.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

3.1 Илрүүлэлт:

Тус байгууллага мөрдөж байгаа хоёр НБББББ байгаа боловч уг бодлого өөрийн үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тухайлбал байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох эмийн үйлдвэрийн орлогын бүртгэл, өртөг болон зардлыг хэрхэн бүртгэх тухай тодорхой заагаагүй байна.

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг, батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэстэй нийцэхгүй байна.

3.2 Эрсдэл:

НБББББ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулаагүйгээс байгууллагын онцлогтой холбоотой бүртгэл тайлагнахыг буруу илэрхийлэх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсний дагуу НБББББ-т өөрчлөлт сайжруулалт хийх.

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2021 онд НБББББ баримт бичгийг эцэслэн дуусгах мөн, шинээр салбарын НБББББ-ын баримт бичиг тусгуулан ажиллаж байгаа.

4 Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Хоёр автомашины шатахууны зарцуулалтыг хянахад нэг нь хэмнэлтэй, нөгөө нь хэтрэлтэй гарч байна. Жолоочийн тооцооны хүснэгтийг үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй 85.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

Эрсдэл:

Шатахуун илүү дутуу зарцуулагдах, дутагдах

4.2 Өгсөн зөвлөмж:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралт Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмжийн 3. Автомашины шатахуун зарцуулалтыг тооцон олгох аргачлал, зөвлөмжийг ашиглах

4.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

5 Хуулийн хэрэгжилтийн талаар

5.1 Илрүүлэлт:

Тайлант онд нийт 437 компанитай худалдан авалт хийсний 19 компанийн гүйлгээ нь и-баримт цахим хуудсанд мэдээлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20.2.4. нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэснийг хэрэгжүүлээгүй байна.

5.2.4.1 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгах
(САГ-2021/82/СТА-ТШЗ)

5.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, 20.2.4-ийг мөрдөж ажиллах

5.4 Байгууллагаас өгсөн харуу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/82/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн программ илүү тооцож тайланд тусгасан.	10,485.5	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Ч.Чимэдрагчаа Г.Батчимэг
2	Үндсэн хөрөнгөнд элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн 232 нэр төрлийн 2,136 ширхэг 417,909.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Тэдгээрийн ашиглалтын байдал тооллогын бүртгэлээр чанар байдлыг тодорхойлоогүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Ч.Чимэдрагчаа Г.Батчимэг
3	Тус байгууллага мөрдөж байгаа хоёр НБББББ байгаа боловч уг бодлого өөрийн үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тухайлбал байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох эмийн үйлдвэрийн орлогын бүртгэл, өртөг болон зардлыг хэрхэн бүртгэх тухай тодорхой заагаагүй.	-	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Ч.Чимэдрагчаа Г.Батчимэг
4	Хоёр автомашины шатахууны зарцуулалтыг хянахад нэг нь хэмнэлтэй, нөгөө нь хэтрэлтэй гарч байна. Жолоочийн тооцооны хүснэгтийг үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй.	85.7	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Ч.Чимэдрагчаа Г.Батчимэг
5	Тайлант онд нийт 437 компанитай худалдан авалт хийсний 19 компанийн гүйлгээ нь и-баримт цахим хуудсанд мэдээлээгүй бай		Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Ч.Чимэдрагчаа Г.Батчимэг
ДҮН		10,571.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 194/А0160058
С.М. 2021/182/СТА-ТМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих 269 мэдээллээс 81 мэдээллийг хугацаа хоцроосон, 28 мэдээллийг байршуулаагүй байна
Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.2.-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д. "..., төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол цахим хуудсанд мэдээлж байх, дээрх зөрчлийг арилгах, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн захирал Д.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Б.Лхавгасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
"ГРОУТ ФИНАНС АУДИТ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.СЭРЖМЯДАГ

Б.БЯМБА

